

## **“НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ” ЖУРМЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

### **“Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээ хийх” журмын төслийн тухай**

Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасны дагуу ХНХС, ХЗДХС-ын 2017 оны А/173, А/120 дугаар хамтарсан тушаалаар батлагдан хэрэгжиж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 32 дугаар зүйлийн 32.1-т заасны дагуу нийгмийн ажилтан, хохирогч нь хүүхэд бол Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дугаар зүйлийн 12.3-т заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан Хамтарсан багийн бусад гишүүнтэй хамтран хийж байна.

Энэхүү журмыг шинээр боловсруулсан болон шинэчилэн найруулсан хууль, журмын хэрэгжилтийг хангах, уялдуулах, цахим шинэчлэлийг хөгжүүлж, мэдээллийн сан шинээр үүсгэж байгаатай холбогдуулан дахин боловсруулах шаардлага үүссэн. Тухайлбал,

#### **Хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд:**

Хүүхэд хамгааллын тухай хуулийг шинэчлэн, Нийгмийн ажил, үйлчилгээний тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, Нийгмийн ажил, үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 6949:2021 стандартыг батлуулаад байна.

Түүнчлэн “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам” (ХНХС-ын 2021 оны А/218 дугаар тушаал), “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам” (ХНХС-ын 2020.06.26-ны А\148), “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ТББ-ыг магадлан итгэмжлэх журам” (ХНХС-ын 2021 оны А/210 дугаар тушаал), “Хамгааллын үйлчилгээний норматив зардал, санхүүжүүлэх аргачлал” (ХНХС, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар хамтарсан тушаал) зэрэг нийт 6 журам, 1 стандарт, 1 зардал тооцох аргачлалыг шинээр батлан, үйл ажиллагаанд мөрдөгдөж байна.

#### **Цахим шинэчлэл шинэчлэлийн хүрээнд:**

Нийгмийн ажил, үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх тогтолцооны шинэчлэлийн хүрээнд Нийгмийн ажил, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан /НАМС/, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлсэн үйлчилгээний мэдээллийн сан /etuslamj.mn/ зэрэг мэдээллийн сангуудыг шинээр хөгжүүлээд байна.

Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх туслалцаа, үйлчилгээг баг, хороодын нийгмийн ажилтнууд удирдан, Хамтарсан багийн бусад гишүүдтэй хамтран үзүүлдэг бөгөөд эрсдэлийг тодорхойлж, нөхцөл байдлыг үнэлэн, цаашид үзүүлэх үйлчилгээг тодорхойлох зорилготой “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн боловсруулах шаардлагатай эсэх талаар урьдчилсан хэлэлцүүлэг явуулсан. Үүнд:

- Баг, хорооны нийгмийн ажилтнууд, Хамтарсан багийн гишүүдээс урьдчилсан байдлаар авсан саналаар гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийг тогтоох хэсэгт тоон утгаар илэрхийлж тооцдог болох;
- Нөхцөл байдлын үнэлгээний маягтыг хялбаршуулж өгөх;
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг эрсдэлд өртсөн бусад хүүхдээс ялгаж таньж тогтоох асуудлыг тодорхой болгож, тоон утгаар илэрхийлж эрсдэлийг тооцох;
- Үйлчилгээний хэсгийг нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан гаргах зэрэг саналууд гарсан тул дээрх зарчмын саналыг тусган, шинэчлэн боловсруулах ажлыг шат дараатай эхлүүлсэн.

Боловсруулалтын явцад Улсын хэмжээнд санал авах уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах, холбогдох байгууллагуудын санал, зөвлөмжийг судлан төсөлд тусгах ажлыг үе шаттай хэрэгжүүлсэн. Тухайлбал,

- Тус яамны захиалгаар 2020 онд Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвөөс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой батлагдсан зарим журмуудад хийсэн үнэлгээний тайлангийн зөвлөмж;
- Орон нутгийн (баг, сум) нийгмийн ажилтнуудыг оролцуулсан цахим болон биеэр оролцуулсан шаталсан сургалт, хэлэлцүүлэг;
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын албан хаагчид, ТББ-ын төлөөллийн бүрэлдэхүүнийг оролцуулсан хэлэлцүүлэг;
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлдэг Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байр, баг хороодын нийгмийн ажилтнуудаас санал авах хэлэлцүүлэг;
- Хэлэлцүүлэгт оролцсон төр, төрийн бус байгууллагын төлөөллөөс журмын төсөлд тусгахаар ирүүлсэн саналыг хэлэлцүүлэг бүрт хэрхэн тусгасан талаар танилцуулж, санал авсан.

Энэхүү цогц үе шаттай хэлэлцүүлгийн үр дүнд шинэчлэн боловсруулсан журмын төсөлд дараах зохицуулалтыг шинээр тусгалаа. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийллийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг тодорхойлох 2 багц бүхий 5 маягтыг шинэчлэн боловсруулсан.
- Нөхцөл байдлын үнэлгээний багц маягтууд хоорондоо хамааралтай байхаар уялдаа, холбоог бий болгосон. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийг тогтоох маягтыг шинээр оруулсан. Нийгмийн ажилтан, цагдаагийн ажилтан бус Хамтарсан багийн гишүүдтэй хамтран эрсдэлийг 7 бүлэгт харъяалагдах 40 асуулгын хүрээнд 4 түвшингээр үнэлж, эрсдлийн түвшин бүрт шаардлагатай туслалцааг үзүүлэхээр зааж өгсөн.

- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид учирсан, учирч болзошгүй сөрөг үр дагаврыг тодорхойлж дүгнэх “Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээ” -г бичиглэл багатай байхаар тооцож, сонгох асуултуудад тохирох хэсгийг бөглөх хэлбэрээр оруулсан.

- Нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлт хэсгийг нийгмийн ажилтан өөрийн мэргэжлийн ажлын хүрээнд ажиглалт, дүгнэлтээ үнэлэх тэмдэглэл хэсгийг нэмсэн.

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуульд нөхцөл байдлын үнэлгээ нь дүгнэлт хэлбэртэй байхаар заасан байдаг тул нэгтгэсэн дүгнэлтийг эрсдлийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлаж дүгнэхээр оруулсан.

- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээг тодорхойлохдоо эрсдлийн үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан хохирогчдод үзүүлэх 7 төрлийн үйлчилгээнээс үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээ авах байгууллага, хүний нэр, төлөвлөж буй хугацааг заавал тодорхой бичиж байхаар тусгасан.

- Үйлчилгээг төлөвлөхдөө үйлчлүүлэгчийн болон гэр бүлийн бусад гишүүдийн тусгай хэрэгцээнд тулгуурласан болон бусад нэмэлт үйлчилгээг зааж өгөхөөр тусгасан.
- Хүүхдийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээнд 2 багц маягт байхаар тооцсон. Энэ хэсэгт нийгмийн ажилтнуудаас хамгийн их санал гарсан бөгөөд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдээс гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хэрхэн таньж тогтоох талаар шинээр тусгах хэрэгтэй гэж үзсэн тул багц маягтуудаас 1 маягтыг шинэчилж, 1 маягтыг хуучин хэвээр нь ашиглахаар боловсруулсан.
- Харин бусад маягт, бичиг баримтыг Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд туслалцаа, үйлчилгээ үзүүлэхэд илүү тохиромжтой байдлаар шинээр боловсруулсан.
- Гэр бүлийн хүчирхийлэл, хүчирхийллийн эрсдэлийг тогтоох “Хүүхдийн гэр бүлийн хүчирхийллийн эрсдэлийг тогтоох маягт”-ыг шинэчилж, эрсдлийн түвшинг тооцох аргачлалын хамт оруулсан.
- Гэр бүлийн хүчирхийллээс хүүхдэд учирсан, учирч болзошгүй сөрөг үр дагаврыг тодорхойлж дүгнэх “Хүүхдийн гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл

байдлын үнэлгээний маягыг дахин шинэчлэх шаардлагагүй, ашиглахад ойлгомжтой, энгийн байдаг гэсэн тул хуучин хэвээр ашиглахаар тогтсон.

- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх бие даасан журам батлагдаж, хэрэгжиж байгаа тул үйлчилгээ үзүүлэх хэсгийг хассан.

Тус журмыг Нийгмийн ажил, үйлчилгээний мэдээллийн санд байршуулснаар нийгмийн ажилтнуудын ачааллыг хөнгөвчлөх, мэдээлэл дутуу орхигдох, заавал үзүүлэх үйлчилгээг сануулах зэрэг ач холбогдолтой.

Мөн цагдаагийн ажилтан дуудлагаар ирэхдээ зөвхөн тухайн үеийн нөхцөл байдлыг үнэлдэг бол нийгмийн ажилтан, Хамтарсан багийн гишүүдтэй хамтран эрсдэлийг үнэлэх боломжтой болсноор гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг болон түүний гэр бүлийн бусад гишүүдийг болзошгүй эрсдлээс хамгаалах боломж бүрдэх юм.

## ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ